

ОУВС Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн 1, 2-р үнэлгээний тайланг гаргалаа

ОУВС-ын Жоф Готлиб /Geoff Gottlieb/-оор ахлуулсан баг 2017 оны 10 сарын 18-30-ны өдрүүдэд Монголд ажиллан хөтөлбөрийн 1, 2-р үнэлгээний үр дүнг хэлэлцсэн байна. Жоф Готлиб Монголын үнэлгээний үр дүнг дараах байдлаар дүгнэсэн байна.

- Монголын эдийн засаг хүлээж байснаас хурдан сайжирч байгаа бөгөөд нүүрсний экспорт, үйлчилгээний салбарын сэргэлтээс шалтгаалан 2017 онд дор хаяж 3.3 хувиар өсөхөөр байна. Мөн ДНБ-ий өсөлт 2018 онд илүү сайжрахаар байгаа боловч нүүрсний салбарын эрсдэл байсаар байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилт сайн байгаа бөгөөд үр дүнгийн тоон үзүүлэлтүүд бүгд зорилтдоо хүрсэн. Төсвийн үзүүлэлтүүд мөн төсөөлснөөс сайн буюу ДНБ-д харьцуулсан алдагдлын хэмжээ 2016 онд 17 хувь байсан бол энэ жил 7.5 хувь байхаар байна.
- Урт хугацаанд хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг авчрахаар цаашид хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд татварын бодлогыг сайжруулах, санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчинг сайжруулах зэрэг ажлууд хийгдэж байна. Банкуудын активын чанарын үнэлгээний үр дүн 12 сарын дундуур гарахаар байна.

Монгол Улс дэлхийн зах зээл дээр 800 сая ам.долларын бонд босголоо

Монголын засгийн газрын бондыг худалдан авах захиалга 335 данснаас ирсэн бөгөөд нийт 5.5 тэрбум ам.долларт хүрсэн байна. Бондын хөрөнгийг 2018 онд хугацаа нь дуусах 500 сая ам.доллар Чингис бонд, 1 тэрбум юаны Дим Сам бондын эргэн төлөлтийг хийхээр төлөвлөж байна.

Макро эдийн засгийн онцлох үзүүлэлтүүд

Улирлын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016			2017								
		4-р улирал			1-р улирал			2-р улирал			3-р улирал		
БДНБ өсөлт ¹	%	1			4.2			5.3					
Улсын гадаад өр / НДНБ ²	%	248			246			234					
Ажилгүйдэл	%	8.9			9.1			9.6					
Сарын үзүүлэлтүүд		10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9
Улсын жилийн инфляци	%	0.1	0.2	1.1	1.9	2.1	2.5	3.4	3.7	3.3	3	5	5.8
Мөнгөнийн нийлүүлэлт M2	Их наяд. Төг	11.5	11.6	12.1	11.9	12.3	12.2	12.4	12.9	13.5	14	14.4	14.8
Гадаад худалдааны тэнцэл ³	Сая. Ам.доллар	958	1197	1559	151.4	334.2	523.7	782	1021	1175	1183	1348	1452
Урсгал тэнцэл ⁴	Сая. Ам.доллар	-564	-488	-449	-85	-94	-171	-157	-166	-294	-392	-368	414
Төлбөрийн тэнцэл ⁵	Сая. Ам.доллар	-278	12	-18	-176	-250	-164	-96	-101	-74	-49	215	202
Ам.долларын ханш /сарын эцэст/	Төг	2374	2467	2489	2459	2463	2447	2419	2402	2350	2445	2430	2464
Гадаад валютын нийт албан нөөц	Сая. Ам.доллар	1039	1304	1296	1117	1048	1109	1231	1235	1319	1363	1599	1627

¹Оны эхнээс хуримтлуулж тооцсон БДНБ-ий жилийн өсөлт

²Дөрвөн улирлын НДНБ-ий нийлбэрээр жилийн НДНБ-ийг тооцсон

³Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээ, оны эхнээс хуримтлуулж тооцсон

⁴Оны эхнээс хуримтлуулж тооцсон


⁵Төлбөрийн тэнцэлийн алдаа, орхигдуулгыг оруулсан, оны эхнээс хуримтлуулж тооцсон

1. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2017 оны 9 дүгээр сард 14 сая ам.долларын гарах урсгалтай гарсан бөгөөд оны эхнээс хуримтлуулсан дүнгээр 202 сая ам.долларын орох урсгалтай гарсан байна. Урсгал тэнцэл тухайн сард 46 сая ам.долларын гарах урсгалтай, оны эхнээс 414 сая ам.долларын гарах урсгалтай, хөрөнгийн тэнцэл тухайн сард 5 сая ам.доллар, оны эхнээс 45 сая ам.долларын орох урсгалтай гарсан байна. Харин санхүүгийн тэнцэл тус сард 36 сая ам.долларын гарах урсгалтай, оны эхнээс 613 сая ам.долларын орох урсгалтай буюу цэвэр зээллэгтэй гарсан байна.

Төлбөрийн тэнцэл

сая ам.доллар




Эх сурвалж: Монголбанк, гадаад секторын статистик

2. Гадаад худалдаа

Экспорт 2017 оны 9 сард 480 сая ам.доллар, оны эхнээс 4.6 тэрбум ам.долларт хүрсэн. Харин импорт тус сард 377 сая ам.доллар, оны эхнээс 3.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. 2017 оны 9-р сарын экспорт өмнөх оны мөн үеэс 38 хувиар, импорт 13 хувиар тус тус өссөн байна. Ийнхүү гадаад худалдааны тэнцэл оны эхнээс хуримтлагдсан дүнгээр 1.45 тэрбум ам.доллар, 9-р сард 104 сая ам.долларын ашигтай гарлаа. Оны эхнээс хуримтлуулан тооцсон худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 67.5 хувиар өссөн байна. Нийт гадаад худалдааны эргэлтийн хувьд 9-р сард 857 сая ам.доллар байв.

Гадаад худалдааны тэнцэл

Сая ам.доллар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нүүрсний экспорт 2017 оны эхний 9 сарын байдлаар 25.8 сая тонн буюу 1.73 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь нийт экспортын 38 хувийг эзэлж байна. Экспортлосон нүүрсний хэмжээ **өмнөх оны мөн үеэс 59 хувиар өссөн** байна. Харин зэс 10 хувиар, цайр 7 хувиар, боловсруулаагүй газрын тос 5 хувиар тус тус буурсан байна. Алтны экспортын өсөлт 8 сарын байдлаар -13 хувь байсан бол 9 сарын байдлаар 1 хувьд хүрсэн байна. 8-р сард 3 тн, 9-р сард 2тн алт экспортлосноор эхний 9 сарын байдлаар 10 тн алт экспортлоод байна.

Нүүрсний экспорт

Сараар, мянган тонн



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

3. Мөнгөний нийлүүлэлт

2017 оны 9-р сард М2 мөнгө 14.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 1.6 хувь, өмнөх оны мөн үеэс 28 хувиар өслөө. Тус өсөлтөд гадаад валютын хадгаламж 7.7 хувиар, төгрөгийн харилцах өмнөх сараас 2.8 хувиар, валютын харилцах данс 2.1 хувиар тус тус өсч, төгрөгийн хадгалмж 0.6 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. Улирлын нөлөөллийг арилган харвал 9-р сард М2 мөнгө 2.54 хувиар өсч 14.7 их наяд болсон байна.

Мөнгөний нийлүүлэлт

М2 мөнгө /их наяд.төг/, сарын өсөлтийн хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4. Инфляци

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх жилийн инфляцийн төвшин 2017 оны 9-р сарын байдлаар 5.8 хувьд хүрсэн. Өмнөх оны мөн үед инфляцийн түвшин -0.1 буюу дефляцитай байсан.

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5. Улсын төсөв


Төсвийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөг	2017	2018	Өсөлт
Нийт орлого ба тусламжийн дүн	7112.9	7,863	11%
Ирээдүйн өв сан	242	122.7	-49%
Тогтворжуулалтын сан	333	508.7	53%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6537.1	7,231	11%
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9154.5	9651.9	5%
Урсгал зардал	7001.6	7452.2	6%
Хөрөнгийн зардал	1813.5	1989.5	10%
Цэвэр зээл	339.4	210.2	-38%
Тэнцэл	-2,617	-2,420	-8%
Төсвийн тэнцэл / Нэрлэсэн ДНБ	-9.5%	-8.0%	1.5%
ДНБ	27438	30387	2949

Эх сурвалж: Сангийн яам, 2018 оны төсвийн төсөл

2018 оны Төсвийн тухай хуулийн төсөлд нийт орлого ба тусламжийн дүнг 7863.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 9651.9 тэрбум төгрөг, төсвийн алдагдалыг ДНБ-ий 8.0 хувь буюу 2420.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна. Энэ нь 2017 оны төсвийн тухай хуультай харьцуулахад алдагдалыг 8 хувиар бууруулсан байгаа бөгөөд ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээг -8.0 хувь буюу 2017 оноос 1.5 нэгж хувиар бууруулжээ.

Улсын нэгдсэн төсөв

тэрбум төгрөг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Монгол Улсын 2017 оны эхний 9 сарын байдлаар төсвийн алдагдал 737.9 тэрбум төгрөг байна. Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2017 оны эхний 9 сарын байдлаар 5491 тэрбум төгрөг, зарлага 5773 тэрбум төгрөг байна. 2017 оны 7 болон 8 дугаар саруудад төсвийн тэнцэл сарын дүнгээр ашигтай гарч байсан бол 9-р сард 160.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

6. Валютын ханш

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг 2017 оны 9-р сард өмнөх сараас 1.41 хувиар суларч 2464-т хүрсэн бол 10-р сард өмнөх сараас 0.34 хувиар чангарч 2456-д хүрсэн байна.

Ам.долларын ханш

хугацааны эцэст




Эх сурвалж: Монголбанк

7. Улсын гадаад валютын нийт албан нөөц

Гадаад валютын нийт албан нөөц 9-р сард 1627 сая ам.доллар, 10-р сард 1694.4 сая ам.долларт хүрч өмнөх сараас 4.1 хувиар өссөн байна. Оны эхнээс авч үзвэл 30.7 хувиар, өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал 63.1 хувиар өссөн үзүүлэлт юм.

Гадаад валютын нийт албан нөөц

сая ам.доллар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар

БДНБ – Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн

НДНБ – Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн

УНА – Улирлын нөлөөллийг арилгасан

Улирлын нөлөөлөл – Ихэнхи эдийн засгийн үзүүлэлт нь улирлын нөлөөлөл ихтэй байдаг. Жишээ нь ДНБ жил бүрийн эхний улирал бага үзүүлэлттэй гардаг. УНА тодотголтой үзүүлэлт нь улирлын нөлөөллийг арилгасан буюу Х12 загвараар нөлөөллийг арилгасан.

Холбоо барих:

www.golomtbank.com

www.facebook.com/Golomtbank/

Эдийн засагч

Г.Нарангоо

narangoo@golomtbank.com

Г.Ганзориг

ganzorig_gan@golomtbank.com

Энэхүү эдийн засгийн тоймыг Голомт банкны эдийн засагчид бэлдсэн болно. Тойм нь зөвхөн мэдээллийн шинж чанартай бөгөөд мэдээлэл нь аливаа хөрөнгө оруулалтын болон бусад зөвлөмж биш тул энэ төрлийн утгаар шийдвэр гаргалтад нөлөөлөхийг зориогүй болно. Тоймд дурдагдсан мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн найдвартай эх сурвалжуудыг ашигласан боловч зохиогч нь тухайн мэдээлэл, тоон баримтын өмнө хариуцлага хүлээхгүй болно.